



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН
РАШААНТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 05 сарын 02 өдөр

Дугаар А/52

Рашаант сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын хавсралт “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1.5 дахь заалт, Хөвсгөл аймгийн Засаг даргын 1/294 дугаартай албан бичиг, сумын Засаг даргын 2024 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн Засаг даргын дэргэдэх зөвлөлийн 4 дүгээр хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.“Хурдан” нэг цэгийн үйлчилгээ нэвтрүүлэх зардалд 2,900,000 (Хоёр сая есөн зуун мянган) төгрөгийг зарцуулсугай.

2.Төрийн нэгдсэн үйлчилгээний “Хурдан” нэг цэгийн үйлчилгээг шуурхай үзүүлэх зорилгоор дээрх зардлыг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг ЗДТГ-ын нягтлан бодогч (С.Отгонжаргал)-д зөвшөөрсүгэй.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ЗДТГ-ын дарга (Т.Отгонцэцэг)-д үүрэг болгосугай.

ДАРГА

Б.АЛТАНГЭРЭЛ

